**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/157/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.05 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Б.Нарангэрэл<br>Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 6
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 12
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 15
**4.1 Ерөнхий зүйл** ........ 15
**4.2 Материаллаг байдал** ........ 16
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 17
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 17
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 17
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 18
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 18
**5.1 Төлбөрийн акт** ........ 18
**5.2 Албан шаардлага** ........ 20
**5.3 Зөвлөмж** ........ 22
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 23

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/59

танай__________-ны № __________ -т

БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.БҮРНЭЭБААТАР ТАНАА

### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө тооцвол Бууцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан гэж үзэхээргүй байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Аудитаар илэрсэн 322,299.1 мянган төгрөгийн нийт алдаа, зөрчил нь төлөвлөлтийн шатанд урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин болох 7,426.2 мянган төгрөгөөс хэтэрсэн бөгөөд бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 2,714.5 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан;
- Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа 24,886.6 мянган төгрөгийг байгууллагын нярвын дансаар дамжуулан гүйлгээ хийсэн бөгөөд зарцуулалтын тайланг гаргаагүй, 30,738.4 мянган төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтаар нотлогдоогүй;
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулж буй 7,998.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг багийн засаг дарга нартай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн;
- Байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс нь 141,959.0 мянган төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй;
- Өмнөх оноос үүссэн 1,643.4 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй

D- alban bichig 2024 A4 ТООТ

5020225

- Засаг даргын нөөц хөрөнгөөс 13,695.0 мянган төгрөгийн өвс тэжээл худалдан авахдаа гэрээ байгуулаагүй, хөрөнгийг хүлээн авсан акт үйлдээгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.7 “Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.2.3 “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, мөн УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-12 Бараа материал, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Тохиолдсон байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Тасалбар болголт”, “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын дүгнэлтийн үндэслэл болгосон дээрх зөрчил дутагдал нь бидний урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн, аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалтыг ажил гүйлгээний хувьд хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D- alban bichig 2024 A4 TOOT

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

# 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **147,755,550.92** | **177,312,300.04** |
| **33** | **АВЛАГА** | 34,012.92 | 36,214,500.04 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 24,012.92 | 24,500.04 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 10,000.00 | 10,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 36,180,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 00.00 | 36,180,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 147,721,538.00 | 141,097,800.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,900,000.00 | 13,695,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,900,000.00 | 13,695,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 132,821,538.00 | 86,825,418.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,154,838.00 | 4,154,838.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 300,000.00 | 300,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 4,392,000.00 | 8,892,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 123,974,700.00 | 73,478,580.00 |
| 35600 | Мал амьтад | 11,000,000.00 | 40,577,382.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,121,043,971.16** | **2,084,991,767.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,121,043,971.16 | 2,084,991,767.86 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,103,043,971.16 | 2,066,991,767.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,736,867,225.71 | 4,788,862,183.71 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -2,852,573,280.12 | -3,102,316,213.58 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 290,330,500.00 | 277,350,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -235,069,823.79 | -226,417,853.48 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 232,817,023.00 | 210,941,121.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -184,978,436.40 | -150,456,390.04 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 101,447,595.00 | 107,976,135.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -81,874,897.76 | -77,246,721.07 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 00.00 | 27,000,000.00 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 152,111,820.00 | 277,874,720.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -63,033,754.48 | -73,575,713.68 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,000,000.00 | 18,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 13,978,000.00 | 13,978,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -13,978,000.00 | -13,978,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,000,000.00 | 18,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,268,799,522.08** | **2,262,304,067.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,845,851.01** | **2,143,357.41** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,845,851.01 | 2,143,357.41 |
| **413** | **Өглөг** | 2,845,851.01 | 2,143,357.41 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 5,090.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,840,761.01 | 1,643,357.41 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 500,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 500,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,265,953,671.07** | **2,260,160,710.49** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,265,953,671.07 | 2,260,160,710.49 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 520,900,904.00 | 520,900,904.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 520,900,904.00 | 520,900,904.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,325,869,660.88 | 1,320,112,172.30 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,325,869,660.88 | 1,325,905,132.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -5,792,960.58 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 419,183,106.19 | 419,147,634.19 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,268,799,522.08** | **2,262,304,067.90** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **787,288,783.19** | **1,155,497,922.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **238,301,219.68** | **347,291,994.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 238,301,219.68 | 347,291,994.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,000,000.00 | 211,220.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 211,220.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 129.533.305.9 | 268.027.192 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -ҮХ | 107,767,913.78 | 79,053,582.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **548,987,563.51** | **808,205,928.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102,530,858.50 | 33,341,328.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,240,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 97,290,858.50 | 33,341,328.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 442,650,300.00 | 774,864,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 442,650,300.00 | 774,864,600.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 3,806,405.01 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 3,806,405.01 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,020,150,227.91** | **1,190,508,964.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,020,150,227.91** | **1,190,508,964.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 990,219,029.91 | 1,148,052,213.38 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 245,794,635.78 | 404,161,497.57 |
| 210101 | Үндсэн цалин | 189,712,115.88 | 312,232,705.77 |
| 210102 | Нэмэгдэл | 32,719,975.90 | 91,928,791.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,145,000.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 2,771,545.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,445,999.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,969,779.64 | 50,371,248.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,311,528.42 | 34,252,448.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,636,093.16 | 4,029,699.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,200,463.18 | 3,223,760.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 515,141.04 | 805,939.96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,306,553.84 | 8,059,399.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,513,503.40 | 45,517,978.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,463,483.40 | 12,420,522.16 |
| 210302 | Түлш, халаалт | 27,050,020.00 | 32,597,656.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 499,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 51,598,632.80 | 146,239,037.64 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,763,500.00 | 3,838,630.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,798,982.80 | 62,035,082.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 921,700.00 | 4,045,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 960,000.00 | 9,936,955.24 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,154,450.00 | 6,436,550.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 59,946,020.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,562,500.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,562,500.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 72,875,818.79 | 11,958,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 72,875,818.79 | 11,958,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,824,000.00 | 5,540,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,560,000.00 | 5,540,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 264,000.00 | 00.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 103,121,305.56 | 75,893,455.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 99,274,305.56 | 75,893,455.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 27,000.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 60,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,260,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 442,958,853.94 | 408,370,796.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,105,200.00 | 101,753,420.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 392,853,653.94 | 306,617,376.82 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,931,198.00 | 42,456,750.72 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,899,300.00 | 3,228,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 500,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,339,300.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,560,000.00 | 2,728,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,031,898.00 | 39,228,750.72 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,923,787.50 | 39,226,589.72 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | -232,861,444.72 | -35,011,042.10 |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 36,180,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 00.00 | 36,180,000.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 6,961,918.48 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 579,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 6,382,918.48 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | 29,218,081.52 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -232,861,444.72 | -5,792,960.58 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **546,181,158.50** | **808,417,148.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,000,000.00** | **211,220.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,000,000.00 | 211,220.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,000,000.00 | 211,220.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 211,220.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **545,181,158.50** | **808,205,928.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102,530,858.50 | 33,341,328.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,240,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 97,290,858.50 | 33,341,328.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 442,650,300.00 | 774,864,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 442,650,300.00 | 774,864,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **533,240,199.50** | **798,917,248.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **533,240,199.50** | **798,917,248.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **503,309,001.50** | **755,860,497.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 248,777,290.22 | 403,708,853.12 |
| 210101 | Үндсэн цалин | 194,502,181.22 | 284,814,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 31,966,314.00 | 118,894,853.12 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 2,132,156.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,176,639.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,854,599.88 | 50,478,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,072,419.81 | 34,325,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,258,608.29 | 4,038,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,309,997.45 | 3,230,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 458,326.02 | 807,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,755,248.31 | 8,076,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,936,176.40 | 46,912,077.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,079,676.40 | 12,597,901.16 |
| 210302 | Түлш, халаалт | 27,856,500.00 | 33,314,476.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 999,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 48,454,329.00 | 78,123,780.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,848,600.00 | 3,169,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 37,387,979.00 | 61,169,630.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,039,500.00 | 1,513,150.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,499,600.00 | 11,672,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 678,650.00 | 600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,061,000.00 | 6,543,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,061,000.00 | 6,543,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 101,888,160.00 | 81,964,237.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 97,737,160.00 | 77,515,237.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 27,000.00 | 27,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 60,000.00 | 60,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,562,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,337,446.00 | 87,529,650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,337,446.00 | 87,529,650.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,931,198.00** | **43,056,750.72** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,899,300.00 | 3,828,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,339,300.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,560,000.00 | 3,828,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,031,898.00 | 39,228,750.72 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,923,787.50 | 39,226,589.72 |
| 213404 | Хөрөнгийн | 108,110.50 | 2,161.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **12,940,959.00** | **9,499,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,236,004.00** | **9,499,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,236,004.00** | **9,499,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,236,004.00 | 9,499,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 12,236,004.00 | 9,499,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-12,236,004.00** | **-9,499,900.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 704,955.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 520,400,904.00 | 419,183,106.19 | 1,558,731,105.60 | 2,498,315,115.79 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **520,400,904.00** | **419,183,106.19** | **1,558,731,105.60** | 2,498,315,115.79 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 500,000.00 | 00.00 | -232,861,444.72 | -232,361,444.72 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **520,900,904.00** | **419,183,106.19** | **1,325,869,660.88** | 2,265,953,671.07 |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **520,900,904.00** | **419,183,106.19** | **1,325,869,660.88** | 2,265,953,671.07 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 35,472.00 | 35,472.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **520,900,904.00** | **419,183,106.19** | **1,325,905,132.88** | 2,265,989,143.07 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -35,472.00 | 00.00 | -35,472.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -5,792,960.58 | -5,792,960.58 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **520,900,904.00** | **419,147,634.19** | **1,320,112,172.30** | 2,260,160,710.49 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 790,306,300.00 | 735,849,230.28 | 54,457,069.72 | 93.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 790,306,300.00 | 735,849,230.28 | 54,457,069.72 | 93.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 755,136,700.00 | 732,021,230.28 | 23,115,469.72 | 96.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 403,832,000.00 | 403,708,853.12 | 123,146.88 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 284,814,000.00 | 284,814,000.00 | 0.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 119,018,000.00 | 118,894,853.12 | 123,146.88 | 99.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,478,900.00 | 50,478,900.00 | 0.00 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,325,600.00 | 34,325,600.00 | 0.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,038,300.00 | 4,038,300.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,230,600.00 | 3,230,600.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 807,700.00 | 807,700.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,076,700.00 | 8,076,700.00 | 0.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 53,074,100.00 | 46,912,077.16 | 6,162,022.84 | 88.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,750,000.00 | 12,597,901.16 | 6,152,098.84 | 67.2 |
| 210302 | Түлш, халаалт | 33,324,100.00 | 33,314,476.00 | 9,624.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 999,700.00 | 300.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 77,628,200.00 | 77,523,780.00 | 104,420.00 | 99.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,207,000.00 | 3,207,000.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,631,600.00 | 60,531,630.00 | 99,970.00 | 99.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,517,600.00 | 1,513,150.00 | 4,450.00 | 99.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,672,000.00 | 11,672,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 600,000.00 | 600,000.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 600,000.00 | 600,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 600,000.00 | 600,000.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,543,500.00 | 6,543,000.00 | 500.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,543,500.00 | 6,543,000.00 | 500.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 75,449,000.00 | 58,724,970.00 | 16,724,030.00 | 77.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 71,000,000.00 | 54,275,970.00 | 16,724,030.00 | 76.4 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 27,000.00 | 27,000.00 | 0.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 60,000.00 | 60,000.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,562,000.00 | 3,562,000.00 | 0.00 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 87531000.00 | 87529650.00 | 1,350.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 87,531,000.00 | 87,529,650.00 | 1,350.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 35,169,600.00 | 3,828,000.00 | 31,341,600.00 | 10.9 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 35,169,600.00 | 3,828,000.00 | 31,341,600.00 | 10.9 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,339,600.00 | 00.00 | 31,339,600.00 | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,830,000.00 | 3,828,000.00 | 2,000.00 | 99.9 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 790,306,300.00 | 775,075,820.00 | 15,230,480.00 | 98.1 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 789,306,300.00 | 774,864,600.00 | 14,441,700.00 | 98.2 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 789,306,300.00 | 774,864,600.00 | 14,441,700.00 | 98.2 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 211,220.00 | 788,780.00 | 21.1 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 211,220.00 | 788,780.00 | 21.1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23.00 | 22.00 | 1.00 | 95.7 |
| 620001 | Удирдах ажилтан | 09.00 | 09.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 09.00 | 1.00 | 90.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **23.00** | **22.00** | 1.00 | 95.7 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 07.00 | 06.00 | 1.00 | 85.7 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 06.00 | 0.00 | 100.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 08.00 | 08.00 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тайлант он |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **35,909,128.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **35,909,128.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **35,906,967.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **600,000.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **35,306,967.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,306,967.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,161.00** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,161.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,161.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **35,909,128.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **35,909,128.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,909,128.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь Төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх,иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах,ардчилал шударга ёсыг тогтоох, хууль дээдлэх төрийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх,ажил үйлчилгээг хөнгөн шуурхай жигд хүртээмжтэй явуулах,төсөв санхүүгийн хэмжээг тодорхойлох, эцсийн үр дүнг үнэлж,дүгнэх,нийгмийн үйлчилгээний чанар,үр ашгийг дээшлүүлэх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тодорхойлжээ.

- Хууль тогтоомжийн эрх зүйн актын сургалт сурталчилгааг өргөжүүлэх,иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах
- Төрийн үйлчилгээг иргэдэд чанартай,хөнгөн шуурхай ,шударга ,хүртээмжтэй хүргэх
- Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах,төсвийн сахилгыг бэхжүүлэх,шилэн дансны тухай хууль,төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ,ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын хэрэгжилтийг хангах
- Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх
- Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах
- Төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,нутгийн захиргааны байгууллагаас гаргах шийдвэрийн үндэслэлийг сайжруулах
- Архив бичиг хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулж,цахимд бүрэн шилжүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Сангийн сайдын 2018 оны тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын жишиг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,454.4 мянган төгрөг буюу 0.3 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3 |
| Авлага | 34.00 | 36,214.50 | 36,180.5 |
| Бараа материал | 147,721.50 | 141,097.80 | (6,623.7) |
| Үндсэн хөрөнгө | 2,121,043.97 | 2,084,991.76 | (36,052.2) |
| **Нийт хөрөнгө** | **2,268,799.50** | **2,262,304.1** | **6,495.4** |
| Өр төлбөр | 2,845.85 | 2,143.37 | 702.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,265,953.67 | 2,260,160.71 | 5,793.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,268,799.52** | **2,262,304.1** | **6,495.4** |

Авлагын дансны үлдэгдэл 36,214.5 мянган төгрөг болж өмнөх оноос 36180.5 мянган төгрөгөөр өссөн байгаа нь тус байгууллагын данс бүртгэлд бүртгэлтэй боловч биетээр байхгүй 36,180.0 мянган төгрөгийн өртөг бүхий моторыг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газраас авлагаар бүртгэх албан бичиг хүргүүлсний дагуу хувь хүнээс авах авлагаар бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 141,097.8 мянган төгрөг болж 6,623.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн худалдан авалтаар 137,630.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийг Онгой байдлын газраас 17,384.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар 29,577.4 мянган төгрөгийн өртөг бүхий мал, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 19,680.0 мянган төгрөгийн өртөг бүхий бусад хангамжийн материал, мөн Засаг даргын Тамгын газраас 12408.2 мянган төгрөгийн өртөг бүхий сэлбэг хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч, бичиг хэргийн материалаас 4,025.0 мянга, барилгын засварын материалаас 2,729.0 мянга, түлш шатах тослох материал данснаас 66,508.1 мянга, сэлбэг хэрэгсэл данснаас 21,409.2 мянга, тусгай зориулалтын материалаас 42,980.8 мянга нийт 223,307.9 мянган төгрөгийг зарцуулсан нь голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,084,991.8 мянган төгрөг болж 36,052.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн худалдан авалтаар 9,499.9 мянга, аймгийн

аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/11 дүгээр тогтоолоор 8,430.0мянган төгрөгийн өртөг бүхий мотоцикл, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/64 дүгээр тогтоолоор 35105.5 мянган төгрөгийн өртөг бүхий худаг, аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар 32,580.0 мянган төгрөгийн өртөг бүхий мотоцикл болон замын бордюр, сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/200 дугаар захирамжаар сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бий болсон 179,664.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 16/49 дугаар тогтоолоор 25,593.3 мянган төгрөгийн балансын үнэ бүхий тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг данснаас хасах шийдвэр гарсны дагуу акталж, мөн аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 31,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг дуудлага худалдаагаар худалдаж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжаар аймгийн Мал эмнэлгийн газарт 19,990.0 мянган төгрөгийн автомашиныг шилжүүлж, мөн орон нутгийн өмчийн тооллогоор дутагдсан 36,180.0 мянган төгрөгийн өртөг бүхий дизель моторыг данс бүртгэлээс хассан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 2,143.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос үүссэн 1,643.6 мянга, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад 500.0 мянган төгрөгийн өглөгийг төлж барагдуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,260,160.7 мянган төгрөг болж 5,793.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 5,793.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 828,723.8 мянга, өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 829,723.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 171,684.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 19,138.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 41,375.2 мянга, бусад урсгал шилжүүлгийг 35169.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 83,920.8 мянга, хангамж, бараа материалын зардлыг 102,726.2 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 87,895.0 мянга, томилолт, зочны зардлыг 24,656.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 51,412.5 мянган төгрөгөөр бууруулж, нийт 790,306.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй гэж үзэхээр байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр 790,308.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 774,864.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 735,849.2 мянган төгрөгийг зарцуулж, 39,226.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 790,308.2 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 93.1 хувийг зарцуулсан байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 123.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,162.0 мянга, хангамж, бараа материалын зардал 104.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 16,724.0 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 31,339.6 мянган төгрөгийг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага** | **790,306,300.00** | **735,849,230.28** | **54,457,069.72** | **93.1%** |
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 481,007,600.00 | 474,627,830.28 | 6,379,769.72 | 98.7% |
| 2 | 80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 113,573,100.00 | 113,562,780.00 | 10,320.00 | 100.0% |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 34,569,600.00 | 3,228,000.00 | 31,341,600.00 | 9.3% |
| 4 | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 79,484,000.00 | 79,482,650.00 | 1,350.00 | 100.0% |
| 5 | 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга | 70,000,000.00 | 53,275,970.00 | 16,724,030.00 | 76.1% |
| 6 | 82212 Хур хог хаягдал, орчны бохирдол | 11,672,000.00 | 11,672,000.00 | 0.00 | 100.0% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 60,631.6 мянган төгрөгийн түлш шатах тослох материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар төлөвлөсөн байна.

Тус байгууллага нь Ник петровис ХХК-тай гэрээ байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 108 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 707,254.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,680.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,426.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,162.0 мянга буюу 11.6 хувиар хэмнэсэн байна.

Бараа үйлчилгээний бусад зардлаас “Байгаль хамгаалъя” дэвжээ тэмцээнийг зардалд 340.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3[1] шатахууны зардлаас нутгийн золголт, уралдаан тэмцээн, туршлага солилцох зэрэгт 2,374.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2[2], 15 дугаар зүйлийн 15.2.3[3] дахь заалтыг зөрчиж зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгөөс Улаанбаатар хотод болсон "Эрдэнэ засгийн хошуу"-ны түүх судалгааны эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахад

[1] Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

[2] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

[3] хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

Кафейна ХХК-аас нэг бүр нь 75.0 мянган төгрөгийн өртөг бүхий 40 хүний хоолны зардалд 3,000.0 мянган төгрөгийн зарцуулсан, мөн сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийг гадаад улсад туршлага судлах аялахад 1,000.0 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3[4], 15.1.3[5], 15 дугаар зүйлийн 15.2.3[6] дахь заалтыг зөрчиж зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.3-д заасан "Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл"-ийг байршуулаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах зөвлөмжийг хүргүүлэв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудитыг 2023 оны 12 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 81,082.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлсэн.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хийж гүйцэтгэсэн бөгөөд тус байгууллага нь түүвэрт хамрагдаж байсан учир аудитаар алдаа, зөрчлийг Бууцагаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд илрүүлж, нэгтгүүлсэн байна.

[4] Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.
[5] хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох
[6] хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тусгайлан авч үзэх шаардлагатай бөгөөд байгууллагын нярвын дансаар дамжуулан анхан шатны баримтаар нотлогдохгүй гүйлгээ хийж байгааг авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 117,904.0 мянган төгрөгийн 4 алдаа[7] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас био технологийн арга хэмжээнд зориулан хүлээн авсан 19,000.0 мянган төгрөгийн өвс тэжээл болон 4,000.0 мянган төгрөгийн хээрийн мэргэчтэй тэмцэх шувууны суудал, 2,753.1 мянган төгрөгийн Цагаан голын эхийг хамгаалах цэвэрлэх ажлыг хүлээн аваагүй, үр дүнг тооцоогүй, хөрөнгөд бүртгээгүй байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, мөн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
2. Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого 26,557.0 мянган төгрөгөөр дутуу, зарлага 26,324.5 дутуу, эцсийн үлдэгдэл 232.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа нь УСНББОУС-12 Бараа материал, мөн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
3. Тухайн байгууллагад бүртгэлтэй боловч биетээр байхгүй 36,180.0 мянган төгрөгийн өртөг бүхий моторыг авлагаар тусгах албан бичиг ирсний дагуу дээрх авлагыг хувь хүнд олгосон зээлийн авлага гэж ангилал буруу бүртгэсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, ангилал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
4. Тайлант онд 3,089.4 мянган төгрөгийн 3 гүйлгээг шууд зардалд бичсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, ангилал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 322,299.1 мянган төгрөгийн 15 зөрчил[8] илэрснээс 7,056.4 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 218,035.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 97,207.1 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 261,667.5 мянган төгрөгийн материаллагаар тооцсон залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 254,241.3 мянган төгрөгөөр их, материаллаг ба өргөн тархсан тул “**Сөрөг**” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1. Бараа үйлчилгээний бусад зардлаас "Байгаль хамгаалъя" дэвжээ тэмцээнийг зардалд 340.0 мянга, шатахууны зардлаас нутгийн золголт, уралдаан тэмцээн, туршлага солилцох зэрэгт 2,374.5 мянган төгрөгийг албан үйлчилгээнээс бусад зориулалтаар зарцуулсан байна.

[7] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
[8] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1[9], 16 дугаар зүйлийн 16.5.5[10] , Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2[11], 15 дугаар зүйлийн 15.1.3[12], 15.2.3[13] гэсэн заалтуудыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хууль тогтоомж зөрчиж зориулалт бусаар зарцуулсан 2,714.5 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх.

5.1.2 Засаг даргын нөөц хөрөнгөөс Хүрээмарал, Бөмбөгөр сумдын 100 жилийн ойд 1,100,0 мянга, Монгол түмний харвуул их наадамд 1,000.0 мянга, аймгийн Мал эмнэлгийн 100 жилийн ойд зориулж 1,100.0 мянга нийт 3,200.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулж, зарцуулалтын тайланг гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4[14], 13.7[15] дахь заалтуудыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Холбогдох хууль, тогтоомжийг зөрчиж, анхан шатны баримтгүй зарцуулсан 3,200.0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх.

5.1.3 Тус сумын Засаг даргад шийдвэргүйгээр 4 дүгээр сард 526.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон, мөн Засаг дарга нь 2023.06.08-ны өдөр томилолтын хуудаст өөрөө өөрийгөө томилж, өөртөө шийдвэр гарган 112.0 мянган төгрөгийн томилолт мөнгийг авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7[16], Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1[17]гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хууль тогтоомж зөрчиж илүү олгосон 638.1 мянган төгрөгийг сумын Засаг даргаар буцаан төлүүлэх.

5.1.4 Тайлант хугацааны түлш халаалтын зардлаас 236.3 мянга, шуудан холбоо интернэтийн төлбөрөөс 34.6 мянган төгрөгийг тээврийн хэрэгслийн даатгалд, бараа үйлчилгээний бусад зардлаас 232.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг төлж зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь 16 дугаар зүйлийн 16.5.5[18] дахь заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хууль тогтоомж зөрчиж зориулалт бусаар зарцуулсан 503.8 мянган төгрөгийг шийдвэр гаргасан холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх.

---

[9] Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах
[10] Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах
[11] Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.;
[12] хууль тогтоомжид заасанаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох
[13] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;;
[14] Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна
[15] Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно
[16] Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно
[17] Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
[18] Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой буюу урьдчилан төлөвлөх боломжтой автомашины сэлбэг хэрэгслийг солиход зориулан нийт 3,580.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам"-ын 2.1.5[19] дахь заалттай нийцэхгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Цаашид засаг даргын нөөц хөрөнгийг урьдчилан төлөвлөж болох боломжтой арга хэмжээнд зарцуулдаг байдлыг таслан зогсоож, цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.2 Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5,298.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, нэмэлт санхүүжилтийн данснаас 2,700.0 мянган төгрөгийн нэг төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээг багийн засаг дарга нартай хийж, санхүүжилтийг хувь хүний данс руу шилжүүлсэн бөгөөд тус ажлыг хүлээн авсан акт үйлдээгүй, гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй, тухайн ажил хийгдсэн талаар нотлох баримт байхгүй байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1[20], Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1[21] дэх заалттай нийцэхгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Хууль журам зөрчиж багийн засаг дарга нартай гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлдэг байдлыг таслан зогсоож, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Байгууллагын даргын 2023.12.11-ны өдрийн А/33 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь 129,805.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 12,153.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг тоолоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1[22] ,13.6[23], 18.1[24], 20 дугаар зүйлийн 20.1.4[25], 20.2.6[26] дэх заалтуудыг зөрчиж байна.

_Шийдвэрлэсэн нь_: Тооллогын комисс нь тооллогыг үнэн зөв тоолж, нягтлан бодогч тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шинээр худалдан авсан 6032.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэлд өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй байна.

[19] энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлнэ.

[20] Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно

[21] Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно

[22] Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно

[23] Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна

[24] Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ

[25] хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

[26] Хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13[27] дахь заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд хийсэн урсгал засвартай холбоотой тооцооллыг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.5 Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллагын нярвын дансаар 24,886.6 мянган төгрөг, Баянбүрд багийн ойн үйл ажиллагаанд зарцуулахаар Хонгор ойл ХХК руу 1,001.8 мянга, дунд ангийн багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, туршлага судлах хүсэлт тавьсны дагуу иргэн У.Даваасамбуугийн дансанд 1,000.0 мянга, тамгын газрын авто машинуудын сэлбэг худалдан авахад 3,850.0 мянган төгрөгийн гүйлгээг хүчин төгөлдөр бус зарлагын баримтыг үндэслэн хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3[28], Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.23[29], 3.4.23.4[30] дахь заалтыг зөрчиж байна.дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчсөн холбогдох буруутай этгээдэд хариуцлага тооцон, төсвийг байгууллагын нярвын дансаар дамжуулан зарцуулдаг байдлыг таслан зогсоож, зарцуулалтын тайланг гарган зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.2.6 Тус байгууллага нь тайлант оны 2,143.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8[31] дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5[32] дахь заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Авлаг, өглөгийг үнэн зөв тооцоолж, тухай бүр нь тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулан өр төлбөрийг барагдуулж, цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.7 Засаг даргын нөөц хөрөнгөөс 2023 оны 11 дүгээр сард 13,695.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг Арслант хүлэг ХХК-иас авсан бөгөөд гэрээ байгуулаагүй, тус өвс тэжээлийг хүлээн авсан акт үйлдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6[33] дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.1[34] дэх заалттай нийцэхгүй байна.

---

[27] Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана

[28] Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ

[29] Дараахаас бусад тохиолдолд зарлагын гүйлгээг гаргахыг зөвшөөрнө

[30] энэ журмын 3.4.7-3.4.8-д заасан үндэслэх баримт дутуу, иж бүрдэл бүрэн бус;

[31] төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

[32] хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь батлаж хэрэгжүүлэх

[33] төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх

[34] Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирж байгаа бараа, материалын үнэ бүхий зүйлс, тоо хэмжээ, зэрэг дугаарын хувьд дагалдан ирсэн баримттайгаа тохирохгүй байх, хайрцаг, сав, баглаа боодол, лоц, ломбо задарч гэмтсэн үед эд хариуцагч санхүүгийн албанд мэдэгдэж байгууллагаас мэргэжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй комисс томилуулж "Бараа, материал хүлээн

*Шийдвэрлэсэн нь*: Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд худалдан худалдан авах гэрээ байгуулж, хүлээн авсан бараа материалыг холбогдох журмын дагуу хүлээн авч, цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.8 Баянхонгор аймгийн Засаг даргын 2023.10.17-ны өдрийн А/557 дугаар захирамжаар аймгийн Онцгой комиссоос нэг бүр нь 20.0 мянган төгрөгийн өртөг бүхий 100ш урьдчилан сэргийлэх эмчилгээний багц, аймгийн Сум дундын ойн ангиас хуваарилсан 5,889.0 мянган төгрөгийн өртөг бүхий тэжээлийг санхүүгийн тайланд бүртгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1[35], 14.4.2[36] дахь заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Байгууллагын хөрөнгөд бүртгээгүй 7,889.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.9 Засаг даргын нөөц хөрөнгөөс Улаанбаатар хотод болсон "Эрдэнэ засгийн хошуу"-ны түүх судалгааны эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахад Кафейна ХХК-аас нэг бүр нь 75.0 мянган төгрөгийн өртөг бүхий 40 хүний хоолны зардалд 3,000.0 мянган төгрөгийн зарцуулсан, мөн сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийг гадаад улсад туршлага судлах аялахад 1,000.0 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3[37], 15.1.3[38], 15 дугаар зүйлийн 15.2.3[39] дахь заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчдөг байдлыг таслан зогсоож, цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.3-д заасан "Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл"-ийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.3[40] дэх заалттай нийцэхгүй байна.

авалтын баримт"-аар хүлээн авна. Комисс "Бараа, материал хүлээн авалтын баримт"-ыг асуултын дагуу 2 хувь нөхөн бичиж 1 хувийг дагалдан ирсэн баримтын хамт эд хариуцагчид, үлдэх хувийг тээвэрлэгчид өгнө.

[35] аж ахуйн бүх ажил, гүйлгээ;

[36] бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

[37] Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.

[38] хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох

[39] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;;

[40] тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

*Өгсөн зөвлөмж*: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.3-д заасан мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст бүрэн мэдээлэх зөвлөмжийг хүргүүлэв.

2. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тус байгууллагын төсөвт хоолны хөнгөлөлтийг батлаагүй байхад байгууллагын даргын 2023.10.23-ны өдрийн Б/38 дугаар тушаалаар 36,575.5 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг байгууллагын дотоод журмыг үндэслэн цалингийн хэмнэлтээс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Хоолны хөнгөлөлтийг олгохдоо цалингийн хэмнэлтээс бөөнөөр нь олгодог байдлыг таслан зогсоож, дотоод журамд заасны дагуу хоолны хөнгөлөлтийг оны эхнээс сар бүр олгохоор төлөвлөлтийг хийх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 2 | 39,269.4 | | | 2 | 39,269.4 | 2 | 39,269.4 | | |
| Санхүүгийн тайланд бүртгээгүй | 2 | 78,634.6 | 2 | 78,634.6 | | | 2 | 78,634.6 | | |
| Дүн | **4** | **117,904.0** | **2** | **78,634.6** | **2** | **39,269.4** | **4** | **117,904.0** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа үйлчилгээний бусад зардлаас "Байгаль хамгаалъя" дэвжээ тэмцээнийг зардалд 340.0 мянга, шатахууны зардлаас нутгийн золголт, уралдаан тэмцээн, туршлага солилцох зэрэгт 2,374.5 мянган төгрөгийг албан үйлчилгээнээс бусад зориулалтаар зарцуулсан байна. | 1 | 2,714.5 | 1 | 2,714.5 | | | | |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс Хүрээмарал, Бөмбөгөр сумдын 100 жилийн ойд 1,100,0 мянга, | 1 | 3,200.0 | 1 | 3,200.0 | | | | |

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Монгол түмний харвуул их наадамд 1,000.0 мянга, аймгийн Мал эмнэлгийн 100 жилийн ойд зориулж 1,100.0 мянга нийт 3,200.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, зарцуулалтын тайланг гаргаагүй байна. | | | | | | | | |
| Тус сумын Засаг даргад шийдвэргүйгээр 4 дүгээр сард 526.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон, мөн Засаг дарга нь 2023.06.08-ны өдөр томилолтын хуудаст өөрөө өөрийгөө томилж, өөртөө шийдвэр гарган 112.0 мянган төгрөгийн томилолт мөнгийг авсан байна. | 1 | 638.1 | 1 | 638.1 | | | | |
| Тайлант хугацааны түлш халаалтын зардлаас 236.3 мянга, шуудан холбоо интернэтийн төлбөрөөс 34.6 мянган төгрөгийг тээврийн хэрэгслийн даатгалд, бараа үйлчилгээний бусад зардлаас 232.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг төлж зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 503.8 | 1 | 503.8 | | | | |
| Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой буюу урьдчилан төлөвлөх боломжтой автомашины сэлбэг хэрэгслийг солиход зориулан нийт 3,580.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан байна. | 1 | 3,580.0 | | | 1 | 3,580.0 | | |
| Байгууллагын даргын 2023.12.11-ны өдрийн А/33 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь 129,805.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 12,153.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг тоолоогүй байна. | 1 | 141,959.0 | | | 1 | 141,959.0 | | |
| Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шинээр худалдан авсан 6,032.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэлд өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй байна. | 1 | 6,032.8 | | | 1 | 6,032.8 | | |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллагын нярвын дансаар 24,886,600 /хорин дөрвөн сая найман зуун наян зургаан мянга зургаан зуун/ төгрөг, Баянбүрд | 1 | 30,738.4 | | | 1 | 30,738.4 | | |

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| багийн ойн үйл ажиллагаанд зарцуулахаар Хонгор ойл ХХК руу 1,001,800 /нэг сая нэг мянга найман зуун/ төгрөг, дунд ангийн багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, туршлага судлах хүсэлт тавьсны дагуу иргэн У.Даваасамбуугийн дансанд 1,000,000 /нэг сая/ төгрөг, тамгын газрын авто машинуудын сэлбэг худалдан авахад 3,850,000 /гурван сая найман зуун тавин/ мянган төгрөгийн гүйлгээг хүчин төгөлдөр бус зарлагын баримтыг үндэслэн хийсэн байна. | | | | | | | | |
| Тус байгууллага нь тайлант оны 2,143.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 2,143.4 | | | 1 | 2,143.4 | | |
| Тус байгууллагын төсөвт хоолны хөнгөлөлтийг батлаагүй байхад байгууллагын даргын 2023.10.23-ны өдрийн Б/38 дугаар тушаалаар 36,575.5 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг байгууллагын дотоод журмыг үндэслэн цалингийн хэмнэлтээс олгосон байна. | 1 | 36,575.5 | | | | | 1 | 36,575.5 |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс 2023 оны 11 дүгээр сард 13,695.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг Арслант хүлэг ХХК-иас авсан бөгөөд гэрээ байгуулаагүй, тус өвс тэжээлийг хүлээн авсан акт үйлдээгүй байна. | 1 | 13,695.0 | | | 1 | 13,695.0 | | |
| Баянхонгор аймгийн Засаг даргын 2023.10.17-ны өдрийн А/557 дугаар захирамжаар аймгийн Онцгой комиссоос нэг бүр нь 20.0 мянган төгрөгийн өртөг бүхий 100ш урьдчилан сэргийлэх эмчилгээний багц, аймгийн Сум дундын ойн ангиас хуваарилсан 5,889.0 мянган төгрөгийн өртөг бүхий тэжээлийг санхүүгийн тайланд бүртгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. | 1 | 7,889.0 | | | 1 | 7,889.0 | | |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс Улаанбаатар хотод болсон "Эрдэнэ засгийн хошуу"-ны түүх | 1 | 4,000.0 | | | 1 | 4,000.0 | | |

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| судалгааны эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахад Кафейна ХХК-аас нэг бүр нь 75.0 мянган төгрөгийн өртөг бүхий 40 хүний хоолны зардалд 3,000.0 мянган төгрөгийн зарцуулсан, мөн сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийг гадаад улсад туршлага судлах аялахад 1,000.0 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.2.3 дахь заалтуудыг зөрчиж байна. | | | | | | | | |
| **Нийт дүн** | **13** | **253,669.5** | **4** | **7,056.4** | **8** | **210,037.6** | **1** | **36,575.5** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.3-д заасан "Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл"-ийг байршуулаагүй байна. | 1 | 60,631.6 | | | | | 1 | 60,631.6 |
| Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5,298.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, нэмэлт санхүүжилтийн данснаас 2,700.0 мянган төгрөгийн нэг төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээг багийн засаг дарга нартай хийж, санхүүжилтийг хувь хүний данс руу шилжүүлсэн бөгөөд тус ажлыг хүлээн авсан акт үйлдээгүй, гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй, тухайн ажил хийгдсэн талаар нотлох баримт байхгүй байна . | 1 | 7,998.0 | | | 1 | 7,998.0 | | |
| Дүн | **2** | **68,629.6** | | | **1** | **7,998.0** | **1** | **60,631.6** |

------------oOo-------------

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 77- А0570241 БНА-2024/157/АА-СТА-ТШЗ Номгон

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа үйлчилгээний бусад зардлаас "Байгаль хамгаалъя" дэвжээ тэмцээнийг зардалд 340,000 /Гурван зуун дөчин мянга/ төгрөг, шатахууны зардлаас нутгийн золголт, уралдаан тэмцээн, туршлага солилцох зэрэгт 2,374,500 /Хоёр сая гурван зуун далан дөрвөн мянга таван зуун/ төгрөгийг албан үйлчилгээнээс бусад зориулалтаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.3 "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.2.3 "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,

5050234

төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Холбогдох хууль, тогтоомжийг зөрчиж, зориулалт бусаар зарцуулсан 2,714,500 /Хоёр сая долоон зуун арван дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн холбогдох шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх[1].

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Бүрнээбаатар, нягтлан бодогч А.Отгонцэцэг нарт хариуцуулав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Б.НАРАНГЭРЭЛ

6417143544
ВЮА0067 2307423

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 78- АО570241 Номгон
БНА- 2024/157/НА- СТА- ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын нөөц хөрөнгөөс Хүрээмарал, Бөмбөгөр сумдын 100 жилийн ойд 1,100,000 /нэг сая нэг зуун мянга/, Монгол түмний харвуул их наадамд 1,000,000 /нэг сая/, аймгийн Мал эмнэлгийн 100 жилийн ойд зориулж 1,100,000 /нэг сая нэг зуун мянга/ нийт 3,200,000 /гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулж, зарцуулалтын тайланг гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050238

1. Холбогдох хууль, тогтоомжийг зөрчиж, анхан шатны баримтгүй зарцуулсан 3,200,000 /Гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийн холбогдох шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх[1].

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Бүрнээбаатар, нягтлан бодогч А.Отгонцэцэг нарт хариуцуулав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Б.НАРАНГЭРЭЛ

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 79- 1050241 БНА- 2024/197/НА-СЯА- тшз Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сумын Засаг даргад шийдвэргүйгээр 4 дүгээр сард 526,100 /таван зуун хорин зургаан мянга нэг зуун/ төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон, мөн Засаг дарга нь 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр томилолтын хуудаст өөрөө өөрийгөө томилж, өөртөө шийдвэр гарган 112,000 /нэг зуун арван хоёр мянга/ төгрөгийн томилолт мөнгийг авсан байна.

